

БАЯНЗУРХ ДҮҮРГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ АЛБА

Огноо: **2019.10.24**

**“БАЯНЗУРХ ДҮҮРГИЙН 87 ДУГААР СУРГУУЛЬД ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ТАВИЛГА
ХУДАЛДАН АВАХ” НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн дугаар:

Баянзурх дүүргийн 87 дугаар сургуульд тоног төхөөрөмж, тавилга худалдан авах ажил

**Харьцуулалт/ гэрээний
дугаар:**

БЗДХААА/201910054

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2019.10.24

Баянзүрх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогдоос *Баянзүрх дүүргийн 87 дугаар сургуульд тоног тохөөрөмж, тавилга худалдан авах ажил, БЗДХААА/201910054 дугаартай тендер-ийг* нийлгүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2019 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 09 цаг 00** минутаас өмнө **цахим системээр** илгээнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 09 цаг 10 минутанд** нээнэ.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Монгол улс, Улаанбаатар
Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө-57
13 дугаар хороо, Засаг даргын Тамгын газрын байр,
1 давхарт 121 тоот, Худалдан авах ажиллагааны алба Утас:70154446
Цахим хаяг: www.tender.gov.mn**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
 - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Унийн санал;
 - (б) Унийн боло нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Унийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Унийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 6.1. Унийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарыт заасан бараа нь **TШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

| | |
|-------------------------------|--|
| | Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ |
| ТОӨЗ-НЫХОЛБОГОДХОЗААЛТ | Шалгуур үзүүлэлт |
| ТОӨЗ 1.1 | <p>1. Сүүлийн 2 жилийн аудитын дүгнэлтийг нотариатаар баталгаажуулан ирүүлнэ. /2017, 2018 он/</p> <p>2. Сүүлийн 2 жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр хийж гүйцэтгэсэн ажлуудийн гэрээний хуулбар, фото зураг, ажил хүлээлцсэн актын хамт ирүүлнэ. /2017, 2018 он/</p> <p>3. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: 2017, 2018 оны аль нэг жилд нэг удаа санал болгож буй үнийн дүнгээсээ багагүй өртөгтэй ажил дээр үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна.</p> <p>4. Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 2 жилийн /2017, 2018 он/ борлуулалтын орлогын дундаж нь санал болгож буй үнийн дүнтэйгээ дүйцэхүйц байна.</p> <p>5. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Санал болгож буй үнийн дүнгийнхээ 50 хувиас багагүй байна. (Үл хөдлөх хөрөнгийн болон бусад хөрөнгийн баталгаажсан гэрчилгээ /Үнэлгээний эрх бүхий байгууллагаар үнэлэгдсэн байх, Үл хөдлөх хөрөнгийн барьцаанд байгаа эсэх талаарх, Эд хөрөнгийн бүртгэлийн газраас гаргасан лавлагaa, барьцаанд тавихыг зөвшөөрсөн албан мэдэгдэл/), (Арилжааны банкны зээлийн тодорхойлолт /Хадгаламж зээлийн хоршоо болон Банк бус санхүүгийн байгууллагын тодорхойлолтыг тооцохгүй/)</p> <p>6. Улсын бүртгэлийн гэрчилгээг эхээс хуулбарлан нотариатаар баталгаажуулсан байх.</p> <p>7. Татварын цахим тайлангийн системээс авсан цахим тодорхойлолт /Татварын өр төлбөргүй байх./</p> <p>8. Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт /өр төлбөргүй байх/</p> <p>9. Харилцагч банкнаас өр авлагын талаарх тодорхойлолт</p> <p>10. Сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн эсэх талаар шүүхийн тодорхойлолт /Шүүхийн ерөнхий зөвлөлийн төрөлжсөн архивын тодорхойлолт болон Захиргааны хэргийн шүүхийн тодорхойлолт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт тус тус ирүүлнэ. /тендер зарласан хугацаанаас хойш/</p> <p>11. Тендерт оролцогч нь хуулийн 14.1-д заасан нөхцөл байхгүй мэдэгдлийг захиалагчид бичгээр гаргаж өгөх үүрэгтэй. Эдгэр нөхцөл үүссэн эсэхийг магадлах зорилгоор захиалагчаас тавьсан шаардлагын дагуу тендерт оролцогч холбогдох баримт, нотолгоог захиалагчид ирүүлнэ.</p> <p>12. Тендерийн баримт бичгийн 5, 6 дугаар бүлэгт заагдсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлэх.</p> <p>13. Үнийн саналыг маягтын дагуу ирүүлнэ.</p> <p>14. Тендерт оролцгчийг төлөөлөн гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг маягтын дагуу нотариатаар баталгаажуулан ирүүлэх</p> <p>15. Шалгарсан тохиолдолд гэрээний үнийн дүндээ багтаан барааг хүлээлгэж өгөх баталгаа гаргаж ирүүлэх. Баталгаа гаргаагүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>16. Эхээс хуулбар хувь хийсэн материалын нь чанарын шаардлага хангахуйц тод гаргацтай харагдахуйц хуулбарласан байх.</p> <p>17. Нийлүүлэх барааны зураг, техникийн тодорхойлолт ирүүлнэ.</p> |

| | |
|-----------------|---|
| | <p>18. Захиалагчийн шаардсан техникийн тодрхойлолт болон стандартад нийцэж буйг батлан ирүүлнэ ./Нийлүүлэх бараа техникийн тодорхойлтоос зөрсөн тохиолдолд тендерээс татгалзах үnlэслэл болно./</p> <p>19. Унийн саналд нийлүүлэх, тээвэрлэх татвар гэх мэт бүх зардал багтсан байна.</p> <p>20. Тендерийн материалд ирүүлж буй тодорхойлолтууд болон нотариатийн он сар нь тендер зарлагдсан өдрөөс хойш байна.</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: Шаардлагагүй.</p> |
| ТОӨЗ 2.1 | <p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn –д өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэг (PKI)-ээр нэвтрэн орж тендерийн материалыа цахим хэлбэрээр ирүүлнэ. Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэр /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100MB-с ихгүй, нэг файлын хэмжээ 15MB-с ихгүй байна.</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 13 хороо, Засаг даргын Тамгын газрын байр, Худалдан авах ажиллагааны алба Давхар болон өрөөний дугаар: 1 давхар 121 тоот Огноо: 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Цаг: 09 цаг 00 минут</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийг хүлээн авах боломжгүй.</p> <p>Тендер хүлээн авах хугацаанаас өмнө илгээсэн тендерийн материалыг буцаан авах, засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй</p> |
| ТОӨЗ 2.1 | <p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 13 хороо, Засаг даргын Тамгын газрын байр</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 1 давхар 121 тоот</p> <p>Огноо: 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдөр</p> <p>Цаг: 09 цаг 10 минут</p> |
| ТОӨЗ 2.3 | <p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <p>1. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах ундэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.</p> |
| ТОӨЗ 6.2 | Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй . |

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт:



| 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдөр | | Улаанбаатар хот |
|-------------------------------------|-------------------------------|---|
| № | Техникийн эд ангийн нэр төрөл | Техникийн үзүүлэлт |
| 1 | 2 | 3 |
| 1 | Тоо ширхэг | 16 ширхэг |
| 2 | Төлөв | Шинэ |
| 3 | Өнгө | Хар |
| 4 | Хэмжээ /өргөн*өндөр/ | Өндөр: 373мм Гүн: 289мм Өргөн: 160мм Жин: 5.9 кг |
| 5 | Процессор / CPU | Хөнгөн цагаанIntel® 8th Generation Core™ i3-8100 (6М Cache, 3.6 GHz) |
| 6 | Шуурхай санах ой / RAM | 4GB DDR4 2400MHz (up to 32GB) |
| 7 | Хатуу диск / HDD | 1TB 7200 rpm SATA 3Gb/s Hard Drive |
| 8 | График карт | Intel® HD Graphics 630 |
| 9 | Оптик драйв | Tray load DVD Drive (Reads and Writes to DVD/CD) |
| 10 | Сүлжээ | Integrated Giga bit 10/100/1000 Ethernet |
| 11 | Оролт гаралтууд: Front | (2) USB 3.0, (1) Universal Audio Jack |
| 12 | Оролт гаралтууд: Rear | (4) USB 2.0 RJ-45 HDMI VGA 3-stack audio jacks supporting 5.1 surround sound (2) PCIe x 1, PCIe x 16, PCI (3653 only) |
| 13 | Power Supply Unit | 290W PSU (EPA Bronze – Full range) |
| 14 | Тоо ширхэг | 1 ширхэг |
| 15 | Төлөв | Шинэ |
| 16 | Өнгө | Хар |
| 17 | Загвар | 3 үйлдэлтэй, хувилах, сканнер, принтер MFC-L5700DN загвартай дүйцэхүйц |
| 18 | Хэмжээ /өргөн*өндөр/ | 435 * 427.5 * 486мм |
| 19 | Хэвлэх | 2 тал хэвлэх |
| 20 | Хорны хэвлэх хүчин чадал | 8000 хуудас |
| 21 | Цаасны хэмжээ | A4 |
| 22 | Хувилах хурд | 40ppm |
| 23 | Төлөв | Шинэ |
| 24 | Нөхцөл | 2 болон 4 ширхэгээр холбох боломжтой |
| 25 | Хурлын сандал | Эвхэгддэг, Зөвлөн суудалтай. Хөлийг нь шаланд бэхэлдэг, Гарын тавиур- Модон материал лацсан, Өндөр чанартай бөх даавуун бүрээстэй, Өндөр нягтралтай зөвлөвч, металл хөлтэй, тэмдэглэл хөтөх эвхэгддэг тавцантай, тав тухтай |
| 26 | Хэмжээ /өндөр*өргөн*урт/ | 1000мм*540мм*820мм /1ш сандлын/ |
| 27 | Даац | 150 кг |
| 28 | Өнгө | Цэнхэр, улаан |
| 29 | Тоо ширхэг | 120 ширхэг |

ХЯНАСАН:
төлөвлөлт, ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ
шинжилгээний хэлтсийн дарга

БОЛОВСРУУЛСАН:
төлөвлөлт, ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ
шинжилгээний хэлтсийн мэргэжилтэн

П.СҮМЬЯСҮРЭН

Л.БАТБАЯР

- 2. Стандарт:** Захиалагч холбогдох стандартыг заана. Эсхүл [Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.] гэж бичнэ
- 3. Баглаа, боодол:** [Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөлийг тодорхой заана. Баглаа боодлын нөхцөлийг цаг уур, давс, барааны жин, ачих буулгах хэрэгсэл, далайгаар тээвэрлэх тохиолдолд хөлөг онгоцны тавцан дээр, эсхүл доор тээвэрлэх зэргийг харгалзаж тодорхойлно. Ачааг хэрхэн тэмдэглэх болон хаяглах, ямар баримт бичиг дагалдахыг энд тодорхойлно.]
- 4. Бараа хүргэх газар:** Баянзүрх дүүргийн 87 дугаар сургууль
- 5. Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

| Нэр | Тодорхойлолт | Тоо ширхэг | Хэм жих нэгж | ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг | Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа | | |
|--------------------------|---|------------|--------------|--|---|---|---------------------------------------|
| | | | | | Нийлүүлэх хамгийн эхний хугацаа | Нийлүүлэх эцсийн хугацаа | Нийлүүлэг чийн санал болгосон хугацаа |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| <i>Процессор</i> | <i>Барааны тодорхойлолт-д заасан байгаа</i> | 16 | ш | <i>БЗД-ийн 87-р сургууль</i> | <i>Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойши ажлын 10 хоног</i> | <i>Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойши ажлын 10 хоног</i> | |
| <i>З уйлдэлт принтер</i> | | 1 | ш | | | | |
| <i>Хурлын сандал</i> | | 120 | ш | | | | |

Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [моо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

| Нэр төрөл | Тодорхойлолт | Барааны гарал Үүслийн улс | Тоо ширхэг | Нэгж үнэ | Нийт дүн | НӨАТ болон бусад албан татвар | Бүгд дүн |
|--------------------|--------------|---------------------------|------------|----------|----------|-------------------------------|----------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| Тендерийн нийт үнэ | | | | | | | |

- Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаarahгүй.

| Гэрээний нэр | Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс | Гэрээний үнийн дүн | Гэрээний эхлэх хугацаа | Гэрээний дуусах хугацаа |
|--------------|--|-----------------------|---------------------------|----------------------------|
| 1. | | | | |
| 2. | | | | |
| 3. | | | | |
| 4. | | | | |
| 5. | | | | |
| бусад. | | | | |

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

| | |
|---|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <i>[moor]</i> жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <i>[GTH-д заасан moor]</i> хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлтэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.] |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд: <ol style="list-style-type: none">1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;5) барааны гарал үүслийн гэрчилгээ. |
| <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> | |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.] |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд: Гэрээний үнийн дүнгийн <i>[moo]¹</i> хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө. |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)² | 9.1. Алданги оногдуулах хувь: <i>[moo]</i> Алдангийн нийт дүн: <i>[moo]</i> |

¹ Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дунгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ³

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны _____ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]-г** (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны _____ дугаар сарын _____-наас _____ оны _____ дугаар сарын _____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]